



МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2020 оны 02 сарын 07 өдөр

Дугаар 26

Чойбалсан

Г 7
Дэд зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2, 20.1.7 дахь заалт, Монгол улсын Засгийн газрын 2012 оны 222 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Дорнод аймгийн нутаг дэвсгэрт олборлох үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүд нутгийн захиргааны байгууллага хоорондын хамтын ажиллагааг сайжруулах, олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлэхэд хяналт тавих, тайлан мэдээг нэгтгэх, олон нийтэд мэдээлэх, сурталчлах үүрэг бүхий аймгийн дэд зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

- Дэд зөвлөлийн дарга: - Аймгийн Засаг даргын орлогч
- Нарийн бичгийн дарга: - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга
- Гишүүд: - Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Эрдэс баялгийн бодлогын хорооны дарга
- Аймгийн ИТХ-ын Уул уурхайн ажлын хэсгийн ахлагч
- Төсвийн ерөнхий нягтлан бодогч
- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Эрдэс баялаг, уул уурхайн асуудал хариуцсан мэргэжилтэн
- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Байгаль орчин, аялал жуулчлалын асуудал хариуцсан мэргэжилтэн
- Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга
- Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга
- Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга
- Аймгийн Татварын хэлтсийн дарга
- Аймгийн үйлдвэрчний эвлэлийн хороо

ТБ-10
ТББ-1
Ат-2


040220024

- “Буйр нуур, Халхгол, Нөмрөгийн сав газрыг хамгаалах хөдөлгөөн” ТББ
- Адуунчулуун ХК
- Шинь Шинь ХХК
- Петрожайна Дачин Тамсаг ХХК

2. Ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлэх дэд зөвлөлийг сумын Засаг даргын орлогчоор ахлуулан иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг оролцуулан байгуулахыг уул уурхай бүхий сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг ханган, зөвлөлүүдийн тайланг нэгтгэн гаргаж жил бүрийн 03 дугаар сарын 15-ны өдрийн дотор багтаан танилцуулж байхыг аймгийн дэд зөвлөлийн даргад даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Я.ХИШИГТОГТОХ